

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр, Пүрэв гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-3

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 4-16

---

<i>1. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг /</i>	4-14
<i>2. “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	14-16

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны  
07 дугаар сарын 06-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 8 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 08 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Анандбазар;

Тасалсан: Г.Амартүвшин.

**Нэг.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Монгол Улсын ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Тавинжил, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын газрын дарга Б.Одонтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа нар танилцуулав.

Мөн Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй, сахилга хариуцлагын, Инновац, цахим бодлогын, Нийгмийн бодлогын, Үйлдвэржилтийн бодлогын, Төрийн байгуулалтын, Хууль зүйн, Эдийн засгийн, Төсвийн байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан тул сонссонд тооцов.

Илтгэл болон аудитын дүгнэлт, Байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад

Монгол Улсын ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

*Уг асуудлыг 9 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Монгол Улсын ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Тавинжил, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын газрын дарга Б.Одонтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

“Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Дэд хорооны дарга Б.Пүрэвдорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Пүрэвдорж:** “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	0
Бүгд	5

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.*

Дэд хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 56 минут үргэлжилж, 8 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 04 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН  
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Б.ПҮРЭВДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
9 цаг 08 минут.

### **ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Пүрэвдорж:** Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, хорооны, Дэд хорооны ирц 62,5 хувьтай бүрдсэн тул Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

**Нэг.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/**

Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн аудитын тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна.

Эхлээд ажлын хэсгийг. Танилцуулчих, ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийн 4 дүгээр номерыг өгье.

**Д.Занданбат:** Дэд хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар танилцуулъя.

1.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт. Монгол Улсын Засгийн газар тайлант онд нэгдсэн төсвийн бодлогоо 9 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорьж дэвшүүлэн ажиллалаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1-д заасан шалгууруудыг хангасан байна. Аудитаар Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүнг 17 их наяд 126,9 тэрбум төгрөг нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 18 их наяд 159,6 тэрбум төгрөгөөр баталгаажууллаа.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг 2 их наяд 891,3 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1 их наяд 32,7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ-ий 2 хувийг эзэлж байна. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулиар баталсан төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад хамаарах 6 их наяд 152,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 их наяд 393,8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй, 1369 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудит хийж гүйцэтгэлийг дүгнэсэн.

Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг батлан хэрэгжүүлснээр эрх зүйн орчин бүрдүүлснээр төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, төсвийн алдагдал буурах, төрийн өмчит байгууллагуудын

ашигт ажиллагаа нэмэгдэх боломжийг бий болгосон байна. Гэвч уг хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд хэрэгжилтийг хэрхэн хангасан талаар ил тод тайлагнах, үр дүнг мэдээлэх зохицуулалтгүй, зарим зүйл, заалтыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх шаардлага байна.

2.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлт. Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 6618 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд төсвийн 57 ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өөрчлөлтгүй 40, хязгаарлалттай 17 дүгнэлт өглөө. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах үндэслэлээр хязгаарлалттай дүгнэлт өгсөн болно.

1.Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр дамжуулан зээлдүүлсэн зээлээс олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 1 их наяд 147,7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй.

2.Засгийн газрын шийдвэрээр Эрдэнэс таван толгой ХК-аас 3 компанид олгосон 44,5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөлт хийгдээгүй хугацаа хэтэрсэн. Монгол Улсын Хөгжлийн банкны үнэ цэн буурсан буюу чанаргүй зээлийн үлдэгдэл 1 их наяд 496,3 тэрбум төгрөг, үүнээс 241,8 тэрбум төгрөг муу зээлийн ангилалд иилжсэн байна. Засгийн газрын тусгай сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн нийт 497,1 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй зэрэг нь санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитын дүн дүгнэлтээс нэн тэргүүнд анхаарах асуудлыг тоймлон танилцуулъя. Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр,

хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүйгээс улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг бодитой үнэлэх боломжгүй байна. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь зөрчил арилахгүй байх гол шалтгааны нэг болж байна.

Орхигдсон болон олон жил үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээг богино хугацаанд ашиглалтад оруулах шийдлийг гаргахгүй байгаа нь төсвөөс санхүүжигдсэн 287,6 тэрбум төгрөг нь үр дүнгүй зарцуулагдах үр дагавар үүсэхээр байна. ЭМД-ын сан болон нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг эрсдэлгүй байлгах зорилгоор Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулсан боловч сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжийг ашиглаагүй байна. Гадаад, дотоодын зээлийн эх үүсвэр болон Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөс иргэн, хуулийн этгээдэд олгосон зээлийн мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн нэгдсэн санд байршуулаагүйгээс хэд хэдэн эх үүсвэрээс давхардуулан зээл аван, зээлийн баталгаа чанаргүй болж гэрээний үүргээ хэрэгжүүлэхгүй, зээлийн эх үүсвэр бүрдэхгүй байх эрсдэл нэмэгдэж байна.

Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд төсвөөс санхүүжих нийгмийн чанартай төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлуудыг санхүүжүүлж байгаа нь төсвийн нэгдсэн бодлогын зарчмыг



алдагдуулж байна. Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах мөн төсөвт ачаалал үүсэж буй талаар жил бүр хийгдэж буй аудитын өгсөн дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа нь төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй зөрчсөн хэвээр байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Улсын Их Хуралд 5 асуудлыг толилуулж, Монгол Улсын Ерөнхий сайдад 16, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 5, Сангийн сайдад 14, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замыг түгжрэл... Үндэсний хорооны даргад 2, Барилга, хот байгуулалтын сайдад 1, төсвийн ерөнхийлөн захирагч нарт 5, аймгийн ИТХ, Засаг дарга нарт 3 зөвлөмж өгсөн болно. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа танилцуулна.

**Х.Булгантуяа:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны ээлжит чуулганы 7 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан байгаа. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллага, төсөл, Төрийн сангийн 5958, Засгийн газрын тусгай сангийн 22, төрийн өмчийн

ААН-ийн 140, орон нутгийн өмчийн ААН-ийн 428 байгууллагын тайланг хамруулсан.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал геополитикийн хурцадмал байдлаас улбаатай инфляцын дарамт, урд хөршид тогтоосон хөл хорио, улс орнуудын төв банкнуудын хэрэгжүүлсэн мөнгөний эрс хатуу бодлого зэрэг нь 2022 онд инфляц, төлбөрийн тэнцлээр дамжин манай улсын эдийн засагт томоохон сорилт бий болгосон. Тухайлбал инфляц 16,9 хувьд хүрч, 2009 оноос хойших хамгийн өндөр түвшинд гадаад валютын албан нөөц 2,6 тэрбум ам.долларт хүрч, 2016 оноос хойших хамгийн бага түвшинд, улмаар эдийн засаг 2022 оны 1 дүгээр улиралд 3,9 хувиар агшаад байсан.

Гэсэн хэдий ч Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд 2022 оны эцэст эдийн засаг 4,8 хувиар өсөж, гадаад валютын албан нөөцийг 3,4 тэрбум ам.долларт хүргэж, инфляцыг 13,2 хувьд хүргэн тогтворжууллаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2022 онд 17,1 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 18,1 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, төлөвлөгдсөн дүнгээс 1,8 их наяд төгрөгөөр буурсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 10,2 их наяд төгрөг, зарлага 11,3 их наяд төгрөг, нийт тэнцэл 1,1 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан нь төлөвлөгдсөн алдагдлаас 1,2 их наяд төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2 их наяд төгрөгөөр сайжирсан үзүүлэлттэй гарлаа.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан танилцуулгатай танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Булгантуяа сайдад баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Доржсүрэнгийн Занданбат Монгол Улсын ерөнхий аудитор, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ядамын Самбууням Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Батжаргалын Заяабал Үндэсний татварын ерөнхий газрын дарга, дахиад Заяабалыг ирэх ирэхгүй бол би хурал хийхгүй шүү. Албан бичиг бичээд хариу өгдөггүй. Энэ ТНБД анхаараарай. Би ерөөсөө хараагүй юм байна. Содномцэрэнгийн Цэрэнбаяр Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, Пүрэвдоржийн Батцэцэг Үндэсний аудитын газрын Захиргаа, хууль эрх зүйн газрын ерөнхий санхүүч, Чойжилсүрэнгийн Тавинжил Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батсүхийн Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны

Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Гэлэгжамцын Энхтайван Гаалийн ерөнхий газрын дэд дарга, Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга, Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Энхтөрийн Батмөнх сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, сангийн Байгалмаагийн Одонтуяа Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Чамбайн Цацрал Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч, Төмөрбаатарын Мөнгөнцэцэг сангийн Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч, Лхагвадоржийн Эрдэнэбадрах Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Мэндээгийн Алтанхорол Сангийн яамны Төрийн сангийн газрын мэргэжилтэн.

Алтанзул нэг юмыг яая, дараагийн 2024 оны төсвийн хууль хэлэлцэж байхад 4 дэх өдрийнх нь, мэдээж 3 дахь өдөр нь бүх Байнгын хороо хуралдаад дүгнэлтээ өгнө. 4 дэх өдрийн өглөө 8 цагт хурлыг нь тавиарай. Ажилдаа ирдэггүй юм байна шүү дээ. Ер нь жоохон шалгаадахъя. Ихэнх нь ирсэнгүй. 4 дэх өдрийн өглөөний мэнд, Булгантуяа бүүр 8 цаг 20 минутад ирчихсэн байна лээ. Баяр хүргэе танд. Танай доод талын хүмүүс чинь Засгийн газрын гишүүнээ гүйцэтгэх албан тушаалтнууд чинь нэг иймэрхүү л байна. Манай Их Хурлын харьяа байгууллага арай гайгүй байгаа биз дээ. Аудитынхан. Ерөөсөө энэ Засгийн газар толгой дээр гараад суучихсан байгаа шүү. Парламент



ямар гэдгийг та нарт үзүүлж болно шүү  
Засгийн газраа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73.4.2-т төсвийн гүйцэтгэлийн 2 дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод, нам, эвслийн бүлэг, төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж гаргасан санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд өгөх ба тус Дэд хороо эдгээр санал, дүгнэлтийг хэлэлцэн нэгтгэн гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулах гэж заасны дагуу Улсын Их Хурлын бүх Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн гүйцэтгэлийг хэлэлцээд санал, дүгнэлтээ Дэд хороонд ирүүлсэн байна. Эдгээр санал, дүгнэлтийг та бүхэнд цаасаар хүргүүлсэн байгаа.

Аюулгүй байдал, гадаад бодлого, бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэн танилцсан байх. Танилцсанд тооцох уу? Тооцлоо.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг бас хүргүүлсэн байгаа. Танилцсан уу? Танилцсанд тооцлоо.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлт та бүхэнд цаасаар хүргүүлсэн байгаа. Танилцсанд тооцлоо.

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг цаасаар хүргүүлсэн байгаа. Танилцсанд тооцлоо.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хүргүүлсэн байгаа. Танилцсанд тооцлоо.

Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хүргүүлсэн байгаа. Танилцсанд тооцлоо.

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хүргүүлсэн байгаа. Танилцсанд тооцлоо.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хүргүүлсэн байгаа. Танилцсанд тооцлоо.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг та нарт хүргүүлсэн байгаа. Танилцсанд тооцлоо.

Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Танилцсанд тооцлоо.

Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг ер нь сонсчихъё. Батжаргал гишүүн Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт нэг. Танд байгаа юу? Бүгдээрээ танилцсанд тооцчихъё. Нэг их тийм Төсвийн байнгын хороон дээр ийшээ чиглэл өгсөн юм байхгүй байгаа биз дээ? Нөгөө, гайгүй юу. Байнгын хорооны хороодоос ирүүлсэн санал, дүгнэлтийг танилцсанаар тооцлоо.

Төсвийн гүйцэтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Кнопоо дараарай. Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Өчигдөр Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулж аудитын үндэслэлийг яахад асуусан асуултдаа хариулт авч чадаагүй. Мэдээж гуравхан минутад бүх зүйлийг асуух боломжгүй, 2 асуулт асуусан, нэгийг нь огт бүүр хариулаагүй. Энэ төрийн аудит гээд зүйлийг бүх шатад л хийдэг. Тэгээд жил болгон л ийм сөрөг дүгнэлттэй, ийм хязгаарлалттай дүгнэлттэй, ийм, ийм үйлдлүүдийг зөрчсөн байна гэдэг. Тэгэхдээ эндээ хэдэн удаа арга хэмжээ авсан, ямар хүн ажлаас чөлөөлөгдсөн, ямар, ямар арга хэмжээ авсан, улсын хэмжээнд хэдэн хүн байдаг юм бэ, яам тамгын газрын хувьд хэдэн хүн байдаг юм гэсэн асуултад хариулаагүй. Хариулахыг бодохгүй, хүсэхгүй байх шиг байна лээ. Тэгэхээр энэ

ямар учиртай юм бэ, энэ тийм нууц байдаг юм уу яадаг ийдэг юм.

Ер нь төрийн аудитын байгууллага бол аливаа үйл ажиллагаанд яг бодит нөхцөл байдлаар хангагдах ёстой юм байгаа юм. Үг, үсгээр хөөцөлдөөд аливаа зүйлийг буруутгахын тулд явах юм бол буруугүй зүйл гарахгүй. Тэгэхээр зөв хийж үү гэхээсээ илүү зөв үр дүнтэй зүйл хийж үү гэдэг ийм сэтгэл зүйтэй, ийм харилцан ойлголцолтой байх ёстой гэж ингэж боддог. Миний хувьд бас орон нутагт төсвийн ерөнхийлөн захирагчийг олон удаа хийж байсан. Олон ажил хийж бас энэ аудитын байгууллагатай хамтарч ажиллаж байсан. Зарим шалгалт бол зөв зүйл хийж байна уу гэхээсээ илүү үг, үсгээр хөөцөлдсөн, тэр хуулийн тэр үг, үсэг нь яг ингээд заачихсан байна, яг энэ тоо ингээд зөрчихсөн байна гээд бүүр нэг, бүүр анхнаасаа буруутгалын шинжтэй явж байдаг. Энэ зүйл дээр ер нь ямар бодлого баримталж явдаг юм бол гэсэн энэ зүйлийг асууя нэмж. Дээр нь ер нь улсын хэмжээнд энэ та бүхний шалгалтын явцад хэдэн хүн ажлаасаа чөлөөлөгдсөн, хэдэн хүн ямар арга хэмжээ авсан талаар нэг тодорхой мэдээлэл авъя. Тэгээд тодруулъя. Өчигдрийн асуултад хариулаагүй юм.

**Б.Пүрэвдорж:** 4 номер, Занданбат дарга.

**Д.Занданбат:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. Өчигдөр Зарлагын дэд хорооны даргад бид нар яг энэ асуудлаар судалгаа гаргасан, судалгаа гаргаж хүргүүлсэн. Өнөөдөр бас Зарлагын дэд хорооноос энэ холбогдох шийдвэрийг бас гаргах байх гэж бодож байна. Зүгээр ийм Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 26,5 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 239 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг холбогдох дээд шатых нь албан тушаалтанд хүргүүлсэн гэсэн ийм дүн мэдээ байна. 30 тэрбум төгрөгийн 25 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. Үүнээс улсын төсвийн ерөнхий

захирагчдын аудитаар биш ээ энэ чинь юу билээ, 22 тэрбумын зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 147 санал хүргүүлсэн. 24 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. Нэг нь санхүүгээр, нэг нь төсвийн гүйцэтгэлээр гэсэн үг. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын аудитаар гэдэг нь орон нутагт хийгдсэн аудитаар 4,4 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан нийтдээ албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 92 саналыг хүргүүлсэн. 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн гэсэн ийм тоо мэдээ тайланд дурдагдсан байгаа.

Таны ярьж байгаа ер нь энэ аудитын дүнд энэ санхүүгийн зөрчлийг, санхүүгийн сахилга хариуцлагыг бид бас их байна, бага тоо хэмжээгээр нь харж бага зөрчил, их зөрчил гэж ярьдаг. Аудитын хувьд бол энийг тэгж ойлгодоггүй. Ер нь бол санхүүгийн сахилга хариуцлага сул байгаа нь бол энэ алдаа зөрчлийн тоо хэмжээгээр илэрхийлэгддэг. Үүнийг бол бид юу гэж хардаг вэ гэхээрээ ерөөсөө санхүүгийн сахилга бат муу байгаа тохиолдолд хээл хахууль, авлигын энэ асуудал, өмч хөрөнгө үрэгдүүлэх асуудал бол байх үндсэн суурь байдаг. Тийм учраас аудит тэр алдааг хүртэл бид нар бол санхүүгийн сахилга хариуцлага муу байгаагийн илрэл гэж бас үздэг.

Аудитын байгууллага бол хариуцлага тооцдог байгууллага ерөөсөө биш. Энэ хууль, эрх зүйн орчноороо. Холбогдох албан тушаалтанд нь л санал хүргүүлдэг. Холбогдох албан тушаалтан нь хариуцлага тооцсон байгаагүй нь бол бид нар тодорхой албан шаардлагын хэрэгжилтийг, жишээлбэл бид нар 22 оны төсвийн гүйцэтгэл яригдаж байгаа бол энд нь өгсөн албан шаардлагыг бид нар 23 оны эцэст 12 сарын 1-нд нэгтгэж авч тоон мэдээ гаргаж, Төсвийн байнгын хороонд хүргүүлдэг ийм л хууль, эрх зүйн орчинтой байгаа.

**Б.Пүрэвдорж:** Батсуурь гишүүн тодруулъя.

**Ж.Батсуурь:** 30 орчим тэрбум төгрөгийн алдаа дутагдал, 236 хүнийг дээд байгууллагууд нь хариуцлага тооцуулахаар хүргүүлсэн боловч оны эцсээр л гарах байх. Одоогоор бол хариуцлага тооцчихсон зүйл байхгүй. Бид нар хариуцлага тооцох эрх байхгүй л гэсэн юм яриад байна л даа. 22 оны гүйцэтгэл ийм байдаг байж.

Тэгвэл 21 оны гүйцэтгэлийн зөрчлөөр хэдэн хүн арга хэмжээ авхуулсан байдаг юм бэ? 22 оных 23 онд гарна гэж байна. Тэгвэл 21 онд ер нь үндсэн Төрийн аудитын байгууллага гэж асар том бүтэцтэй байгууллага байгаад байдаг, хянадаг, шалгадаг. Тэгээд сүүлдээ бид нар бол хариуцлага тооцох эрх байхгүй гээд байдаг. Тэгээд хариуцлага тооц гээд тухайн төсвийн ерөнхийлөн захирагч Ерөнхий сайд шат шатын хүмүүст өгөхөд тэр хариуцлагыг тооцдоггүй юм бол энийг хянах, аудитлах хэрэг байна уу? Тэгэхээр.../минут дуусав/

**Б.Пүрэвдорж:** Нэмээд нэг минут тодруулах эрхтэй шүү дээ та. Батсуурь гишүүний микрофон өгчихье.

**Ж.Батсуурь:** 22 оны энэ хариуцлага тооцсон материал бүр ирээгүй байна гээд байгаа байхгүй юу. 23 онд гүйцэтгэх. Тэгвэл 21 онд хэдэн хүнд хариуцлага тооцсон байдаг юм бол? Ирснийг нь сонсьё.

**Б.Пүрэвдорж:** 3 номер, хэн байсан, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг.

**Ц.Наранчимэг:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. 2021 оны улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын тайлангаар 152 албан тушаалтанд, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын тайлангаар 119 албан тушаалтанд, нийт 271 албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг хүргүүлсэн. 21 оныхоор манай үйл ажиллагааны тайлангаар

хариуцлага тооцох албан шаардлагын хэрэгжилт бол 90,4 хувьтай байна. Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан сөрөг дүгнэлт авсан бол хариуцлага тооцох албан шаардлагыг бас хүргүүлнэ. Татгалзсан санал, дүгнэлтийг төрийн аудитын байгууллага өгсөн бол ажлаас чөлөөлөх ийм албан шаардлагыг хүргүүлдэг. Тэгэхээр 2021 онд нийт улсын төсвийн 4, орон нутгийн төсвийн 10 байгууллагад татгалзсан санал, дүгнэлт өгсөн. Нийтдээ 14. 14 байгууллагаас бол эдгээр албан тушаалтнуудыг ажлаас нь чөлөөлсөн байгаа. Жишээ нь.../минут дуусав/

**Б.Пүрэвдорж:** Дахиад 3 номер дээр нэг минут нэмээд тайлбарлачихъя.

**Ц.Наранчимэг:** Хөдөө аж ахуйг дэмжих сан, Монгол Кувейт зэрэг байгууллагууд ажлаас чөлөөлсөн саналуудаа ирүүлсэн. Ерөнхийдөө нийт албан тушаал манай төрийн аудитын байгууллагаас түрүүн бас Монгол Улсын ерөнхий аудитор хэллээ. Хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлээд, эргээд хариуцлага тооцож байгаа биелэлтүүд нь бол бид дарга, санхүүгийн ажилтнууд, мөн хууль тогтоомж зөрчсөн бол тэдгээр хүмүүсийнх нь албан тушаалыг яг тэр шийдлийг гаргасан албан тушаалтнуудыг зааж албан шаардлагаа өгдөг байгаа. Тэр албан шаардлагын хариуцлага тооцох албан шаардлагын биелэлтүүдийг бол тухай бүрд нь ирүүлдэг. Хэрвээ ирүүлээгүй бол бас албан шаардлагыг биелүүлээгүй бол дээд шатных нь томилдог эрх бүхий албан тушаалтанд нь дараагийн аудитаар нь албан шаардлага хүргүүлдэг ийм хуулийн зохицуулалттай. Түрүүн Монгол Улсын ерөнхий аудитор хэлсэн энэ зохицуулалтаар явж байгаа.

**Б.Пүрэвдорж:** Би нэг хэд хэдэн асуулт байна. Яг энэ 2022 оны төсвийн гүйцэтгэл дээр яг хэдэн төгрөгийн зөрчлийн дүн гараад байгаа юм бэ? Тэрийг нэг хэлээд өгөөч. 4 номер Занданбат дарга.

**Д.Занданбат:** Монгол Улсын Засгийн газрын 22 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дээр бид нар санхүүгийн тайлангийн түвшинд нийтдээ 5 их наяд 108,4 тэрбум төгрөгийн 12576 зөрчил илрүүлсэн. Үүнд 2279 төлбөрийн акт, 2872 акт тавигдсан, 2872,9 биш ээ, 2 их наяд 872,9 тэрбум төгрөгийн зөрчилд 4029 албан шаардлага хүргүүлсэн. 2 их наяд 130,8 тэрбумд 6004 зөвлөмж өгсөн. 26,5 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 239 санал хүргүүлсэн. 30 тэрбум төгрөгийн 25 асуудлыг хууль хяналтын байгууллагад өгсөн гэж санхүүгийн тайлангаараа хийсэн байгаа.

Нөгөө нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр бол энэ дээр нэмэгдэх нь хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд нь аудит хийдэг учраас тэрэн дээр бас нэг тоо ингээд нэмэгдээд гарна. Бид нар тайлангийнхаа хавсралт хэсэгт энэ тайлангуудыг бол бид нар Улсын Их Хуралд хүргүүлсэн байгаа, гишүүдэд очсон байгаа. Тайлангийн хавсралт хэсэгт бол Засгийн газрын 2022 оны нэгтгэсэн тайланд хийсэн аудитор тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт гэж ингээд бүхэл бүтэн хавсралт болгоод ингээд хийсэн байгаа.

**Б.Пүрэвдорж:** Яг нийтдээ энэ төсвийн гүйцэтгэлтэй холбоотой шийдвэр гаргадаг Монгол Улсын хэмжээнд нийт хэдэн албан тушаалтан байдаг юм бэ?

**Д.Занданбат:** Нийтдээ 57 төсвийн ерөнхийлөн захирагч байгаа. Энэ 57 төсвийн ерөнхийлөн захирагчдад аудитад 57 шүү дээ. 57 төсвийн ерөнхийлөн захирагч байгаа. Үүнээс орон нутаг нь 33, 33 байхаа, орон нутаг нь 22 төсвийн ерөнхийлөн захирагч, бусад нь улсын юу, салбарын яамнууд болон холбогдох байгууллагууд байгаа. 22, 34, 35.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр аудитын байгууллага сүүлийн үед нэлээн сайн ялангуяа төсвийн гүйцэтгэл дээр бас их өндөр дүнтэй 5 их наядын зөрчил илрүүлнэ гэдэг бол бас энэ чинь нөгөө нийт төсвийн чинь 25 хувь нь байна шүү дээ. Тэгэхээр энэ бол сайн үзүүлэлт гэж харж байна. Хамгийн гол нь энэний энэ байнга ингэж гаргаад байгаа, зөрчил гаргаад байгаа тэр хүмүүсээ хариуцлагажуулах тэр асуудал дээр ялангуяа хуульд нь бас юм байхгүй. Тэгээд яг дээд талын албан тушаалтанд нь хариуцлага тооцох тухай албан бичгийг илгээгээд, тэр яг төсвийн ерөнхийлөн захирагч нар нь тэр шийдвэрээ гаргадаггүй ийм тохиолдлууд бас байгаад байх шиг байгаа юм.

Тийм учраас энэ удаагийн хурлаас би нэг ийм албан бичиг Засгийн газар луу явуулах гэж байгаа. Тэгэхээр би энэ юу яахаар тэгье, тэрний дараа. Асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан гарсан. Бүх Байнгын хороод дээр энэ мэдээллүүд яригдаад, бас салбар салбарынхаа чиглэлээр тодорхой санал мэдээллүүд нь яригдчихсан. Тийм учраас энд нэгтгэгдэж бас Засгийн газарт тодорхой чиглэл өгөх барих асуудлууд байгаа. Өчигдөр Төсвийн байнгын хороон дээр тодорхой саналууд яригдсан. Тийм учраас би Төсвийн байнгын хороон дарга тэр талын саналуудаа ярина гэж ингэж ойлгож байна.

Бид хэд ойрын хугацаанд ер нь 2, 3 зүйл дээр анхаарах ёстой юм байна гэж ингэж хараад байгаа. Тийм учраас Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам 2 хамтарч энэ төсөл, арга хэмжээний төсвийн магадлал хийдэг асуудлыг нэг зохих журамд нь оруулахгүй бол болохгүй болчихлоо. Энэ саяын 2, 3 жил чинь үндсэндээ төсвийн нэлээн их өөрчлөлтүүд орж байгаа, үнэ нэмэгдсэнтэй холбогдуулаад магадлал хийлгэх хүсэл



нэлээн их нэмэгдчихсэн. Тийм учраас энэ зураг төсөв дээр магадлал хийдэг асуудлыг гүйцэтгэгч компани барьж яваад байдаг асуудал биш энэ. Үүнийг тэр зураг төсөв зохиосон зохиогч буюу тэр автор, захиалагч 2 л хийх ёстой. Тэгж байж энэ бодитой болох ёстой. Тийм учраас энэ харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн зохицуулалт дээрээ бид тодотгох зайлиггүй шаардлага байгаа юм байна гэж ингэж харж байгаа юм. Ингэж байж энэ төсвийн шинэчлэлийн чинь асуудал их зөв болж явах юм байна гэж ингэж харагдаж байна гэж.

2 дахь бидэнд анхаарах ёстой зүйл дам дамаа Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам 2 анхаарах ёстой. Энэ гадаадын зээл тусламжийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх асуудал дээр бид нэлээн өөр талаасаа харах ёстой юм байна. Дан ганц зээлийн хугацаа, хүү, үйлчилгээний төлбөр гэсэн ийм 3 үзүүлэлт хараад, урт хугацаатай, хямд өртөгтэй зээл гээд яриад байсан чинь ханшийн зөрүү чинь бидэнд өртгийг эрс өндөржүүлж байна. Жишээ нь 2022 оны гүйцэтгэлээс харахад бол 540 орчим төгрөгөөр ханшийн өөрчлөлт үүсэж байгаа явдал нь зээлийн хүүг 10 хэдэн хувиар нэмэгдүүлчхэж байгаа байхгүй юу. Үндсэндээ юу өртгийг, хүүг биш л дээ өртгийг. Тийм учраас бид ийм өндөр өртөгтэй зээл авч ашиглаад байх юм уу? Тийм учраас авч хэрэгжүүлэх гэж байгаа зээлийнхээ хугацаа юмыг харгалзаж, энэ хугацаанд ханшийн ямар зөрүү гарах вэ гэдгийг урьдчилж үнэлж, дүгнэж тооцдог, түүн дээрээ тулгуурлаж ашиглах гэж байгаа хөрөнгийнхөө үнэ цэн өртгийг тооцож байж авдаг барьдаг асуудал руугаа шилжихгүй бол болохгүй нь. Үүнийг энэ холбогдох хууль тогтоомжуудад нь тодотголоор хийх зайлиггүй шаардлага бий болчихсон байна гэж, үүнийг би нэг зориуд хэлмээр байна. Ингэж байж асуудал гарна.

Аудитын байгууллага дээрээ бол би өнгөрсөн жил ч ярьж байсан. Сая өчигдөр Төсвийн байнгын хороон дээр

Наранчимэгийн танилцуулж байгаагаар бол алдаа, зөрчил хоёроо бид ялгаж, тайлагнаж, илэрхийлдэг болчихсон гэж ингэж хэлнэ лээ. Тэр саяын яригдаад байгаа 2 их наяд эд нар гэдэг чинь бол нийт яригдаж байгаа зүйл. Сая Занданбат даргын ярьж байгаагаар бол 30 тэрбумыг хууль хяналтын байгууллага руу, бас 30 орчим тэрбум байв уу 28, 9 гэж би сая тэгж сонслоо. Түүнийг актын хэлбэрээр нь тавьсан гэж. Үндсэндээ 60 тэрбум төгрөгийн асуудал байгаа юм байна. Тэр нь яг нарийндаа эрүүгийн шинж чанартай байж болохоор гэж үзэж байгаа тэр 30 орчим тэрбум төгрөгийнхөө юмыг хууль хяналтын байгууллага руу шилжүүлчихлээ гэж би ингэж ойлголоо шүү дээ. Цаад 29 орчим тэрбум нь бол санхүүгийнхээ хууль тогтоомжийн дагуу шууд манай хяналтын, санхүүгийн хяналтын байгууллагууд акт төлбөрөөр асуудлыг нь юу яаж байгаа, шийдчих тийм эрх нь байгаа юм байна гэж.

Тийм учраас бид энэ санхүүгийн хяналтын байгууллагуудын гаргаж ирж байгаа үр дүн, мэдээллийг бас энэ олон түмэнд их зөв ойлгуулдаг хэлбэр байх ёстой шүү. Үүнийг ер нь бид урьд өмнө нь бол ялгаж салгалгүй ярьдаг. Төсвийнхөө 30, 40 хувиар зөрчил төлбөр үүсгэчихсэн юм шиг харагдуулдаг эд нар нэг ийм байдалтай яваад байсан юм. Тийм учраас үүнийг бид зөв ойлгуулж, зөв ярих ёстой. Тэр алдаануудыг бол бид тухайн хяналт шалгалтын явцад залруулдаг барьдаг ийм зүйлүүд бий. Ингээд би.../минут дуусав/

**Б.Пүрэвдорж:** Тэмүүлэн гишүүн.

**Г.Тэмүүлэн:** 2022 оны төсвийн гүйцэтгэлтэй холбогдуулж бид нар хэд хэдэн арга хэмжээг бас дараа дараагийн төсвийн гүйцэтгэлтэй уялдуулж анхаарах ёстой юм байна гэж үзээд байгаа. Өчигдөр Төсвийн байнгын хороон дээр бол тодорхой санал саналаа хэлсэн. Тэгэхээр үндсэндээ бол Монгол Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгогдсон үндсэн бүрэн эрх бол онцгой бүрэн эрх бол энэ



төсөв батлах, түүний гүйцэтгэлийн тайланг бол батлах асуудал байгаа.

Мөн дээрээс нь яг энэ төрийн санхүү болоод төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлж байгаа байгууллагуудын бүрэн эрх, зохион байгуулалт үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох бол Үндсэн хуулиараа бол Улсын Их Хуралд олгочихсон бүрэн эрхийн асуудлууд байгаа. Тэгэхээр бид бүхний хувьд энэ төсөв санхүүтэй холбоотой, тэр дундаа төсвийн гүйцэтгэлтэй холбоотой энэ хууль, эрх зүйн орчин дээр байгаа хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тодорхой хэмжээнд, магадгүй хариуцлагын санхүү механизмууд дутуу байгаа бол тэрийг сайжруулах, эрх зүйн орчныг нь бий болгох, төсвийн сайн засаглалыг бүрдүүлэх хүрээнд бол тодорхой өөрчлөлтүүдийг бол хийх шаардлагатай байна гэж бол хараад байгаа.

Үүн дотроо онцлох нэг зүйл бол төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхтэй холбогдуулж Улсын Их Хурлаас сонсгол зохион байгуулах, хяналт шалгалт явуулахтай холбоотой хууль, эрх зүйн орчнууд бол бас тодорхой хийдэл, давхардал, зөрчлүүд бол байна гэж хараад байгаа. Үүн дотроо бид нарын хувьд Нийтийн сонсголын тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан энэ хяналтын сонсголыг төсвийн гүйцэтгэлийн хэлэлцүүлэгтэй уялдуулан зохион байгуулах дээр бол цаг хугацааны бас тодорхой зөрчлүүд гарч ирж байна. Хуулийн зөрчлүүд гарч ирж байна. Төсвийн сонсгол зохион байгуулах, хяналтын үүргээ хэрэгжүүлэхэд бас тодорхой цаг хугацааны хувьд бол хүндрэлүүд гарч ирж байгаа юм.

Тэгэхээр 2024 оны төсвийн төсөлтэй хамт тодорхой хуулийн төслүүд бол Засгийн газраас өргөн баригдаж, боловсруулагдаж орж ирнэ. Бид нарын хувьд энэ Улсын Их Хурлын

тогтоолын төсөл дээр тодорхой 4 саналыг бол тодорхой саналыг тусгая гэж оруулж ирж байгаа. Үүн дотор бол 2024 оны төсвийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслүүд дээр 1 дүгээрт энэ Засгийн газраас боловсруулан өргөн мэдүүлж байгаа тухайн жилийн төсвийн төсөл, гүйцэтгэлийн дүн, батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлтэй зөрж байгаад бол дүн шинжилгээ хийх, мөн холбогдох хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хариуцлагажуулах зорилгоор бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа бол өргөн мэдүүлээрэй гэсэн чиглэлийг бол Засгийн газарт өгч байгаа.

2-т саяын түрүүний дурдсан Нийтийн сонсголын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Дэгийн тухай хуульд заасан энэ хяналтын сонсголыг төсвийн гүйцэтгэлийн хэлэлцүүлэгтэй уялдуулан зохион байгуулах энэ шаардлагад нийцүүлж, тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, энэ аудитлах, өргөн мэдүүлэх, батламжлах, энэ хугацаанд бол өөрчлөлт оруулах асуудлыг бас мөн боловсруулж, 24 оны төсвийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх чиглэл бол Засгийн газарт чиглэл болгож байгаа. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой цаглаварт өөрчлөлт оруулах энэ даалгаврыг бол бас Улсын Их Хурлаас өгч байна гэж бол та бүхэн бас ойлгох хэрэгтэй байгаа.

3 дугаарт Монгол Улсын тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулгад төсвийн орлого, зарлагыг эдийн засгийн ангиллаар болон төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн баталсан төсвөөс зөрүүтэй зарцуулсан шалтгааныг бол тайлбарласан дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргаж байх энэ асуудлыг бол бид бүхэн тавьж байгаа. Төсвийн байнгын хороон дээр ярьсан. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73.2 дугаар зүйл дээр бол баталсан төсвөөс зөрүүтэй бол

түүний шалтгааныг тайлбарласан дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргасан байна гэсэн хуулийн заалт байгаад байгаа. Тэгэхээр энэ асуудлыг дараа дараагийн асуудлууд дээр бол анхаарч оруулж ирэх ёстой. Хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх ёстой. Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ёстой гэсэн үүднээс бол оруулж ирж байгаа.

Мөн энэ удаагийн төсвийн төсөл дээр ч, төсвийн гүйцэтгэл дээр ч тэр өмнөх онуудын төсвийн гүйцэтгэлүүд дээр ч тэр гадаад зээл, тусламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү бол жилийн жилд дандаа их байдаг. Тэгэхээр энд бол гүйцэтгэл дээр, төлөвлөлт дээр хийдлүүд бол гарч байна. Магадгүй алдаа оноо байгаа бол үүндээ дүгнэлт хийж, цаашид төсвийг бодитой төлөвлөж ажиллах чиглэлээр бол Засгийн газарт бас үүрэг чиглэл өгсөн ийм 4 заалт бүхий тогтоолын төслийг бол бас санал болгож байгаа. Тэгээд энийг бол Зарлагын хяналтын дэд хорооны гишүүд та бүхнийг бас дэмжиж өгч, энэ тогтоолыг баталж өгөхийг, тогтоолын төслийг Улсын Их Хуралд бас оруулахыг бас хүсэж байна. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Тийм үү? Тэгэхээр энэ асуудлыг дахиад хэлэлцэх асуудлын 2 дахь болгоод оруулчихъя. Тэгээд яагаад гэвэл Тэмүүлэн дарга яг энэ хурлын дундуур оруулж ирсэн учраас энийг нэг асуудал хэлэлцэж байхад давхардуулж хэлэлцэж болохгүй байна. Тийм учраас 2 дахь асуудал болгоод хэлэлцээд явчихъя.

Би бас 2 дахь асуудал дээр энэ төсвийн гүйцэтгэлтэй холбоотой Засгийн газарт чиглэл өгөх тийм албан бичгийг явуулах юм. Тэгээд энэ дээрээ бас та бүхнээс хэлэлцүүлэе гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа. Энэ төсвийн гүйцэтгэл батлах, батлахтай холбоотой тогтоол учраас энэ 73.7-д заасны дагуу шаардлагатай гэж үзвэл Төсвийн зарлагын хяналтын дэд хороо улсын төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

тогтоолын төсөл бол боловсруулж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно гэж. Тийм учраас тусдаа 2 дахь асуудал болгож орохгүй бол болохгүй байна. Гишүүд үг хэлж дууслаа.

9.52 цаг

### **“Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

2 дахь асуудалдаа оръё. Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тогтоолтой, энэ тогтоолыг түрүүн, уншаад танилцуулчихъя. Сүүлийн хувилбар нь наадах чинь уу. Монгол Улсын Их Хурлын тогтоол. 2023 оны ... дугаар сарын ... өдөр, ... дугаар, Улаанбаатар хот. Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний, авах зарим арга хэмжээний тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Нэг.Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

1.Монгол Улсын Засгийн газраас боловсруулан өргөн мэдүүлж байгаа тухайн жилийн төсвийн төсөл, гүйцэтгэлийн дүн батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлтэй зөрж байгаад дүн шинжилгээ хийх, холбогдох хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хариуцлагажуулах зорилгоор холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа боловсруулан Монгол Улсын 2024

оны төсвийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2. Нийтийн сонсголын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хяналтын сонсголыг төсвийн гүйцэтгэлийн хэлэлцүүлэгтэй уялдуулан зохион байгуулах шаардлагад нийцүүлэн Монгол Улсын тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, аудитлах, өргөн мэдүүлэх, батламжлах хугацаанд өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулан Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

3. Монгол Улсын тухайн жилийн төсвийн гүйцэтгэл, гүйцэтгэлийн танилцуулгад төсвийн орлого, зарлагыг эдийн засгийн ангиллаар болон төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн баталсан төсвөөс зөрүүтэй зарцуулсан шалтгааныг тайлбарласан дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргаж байх.

4. Гадаад зээл, тусламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү их байгаад дүгнэлт хийж, цаашид төсвийг бодитой төлөвлөж ажиллах.

Хоёр. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/-д даалгасугай. Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Санал байна уу? Алга байна. Кнопоо дарчих. Ганбаатар гишүүн. Болохгүй, болохгүй болдоггүй юм. Дэг зөрчинө. Намайг огцуулчихна шүү дээ. Баярлалаа. Монгол Улсын 2022 оны төсвийн, үг хэлж дууссан.

Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг болон, аль нь вэ, болон Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай

тогтоолын төслийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт 100 хувийн саналаар дэмжлээ.

Аудитын газар албан бичиг, хариуцлага тооцох тухай албан бичгийг бас юу руу явуулдаг. Төсвийн ерөнхийлөн захирагч нар руу явуулдаг, Засгийн газар луу явуулдаг. Харамсалтай нь энэ дээр тодорхой хариу өгдөггүй, бас зарим албан тушаалаа тушаалтнаа хаацайлж үлддэг ийм тохиолдлууд маш их байгаад байна. Тийм учраас Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы тухай хуулиар, Улсын Их Хурлын тухай хуулиар бид бас тодорхой хэмжээний хариуцлага тооцох, баталсан хуульдаа хяналт тавих ийм заалтууд бий.

Тийм учраас энэ хүрээндээ Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ сайдад холбогдох арга хэмжээ авах тухай ийм албан бичгийг явуулж байгаа. Тэгээд би энэ албан бичгийг та бүхэнд танилцуулъя.

Улсын Их Хурал Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн, нэгтгэсэн тайланг хянан хэлэлцэх явцад төрийн аудитын байгууллагын аудитын дүгнэлтээр сөрөг болон хязгаарлалттай дүгнэлт гарсан төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, Засгийн газрын зарим тусгай сангийн холбогдох эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцсон эсэх нь тодорхойгүй, албан шаардлагыг биелүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр дорвитой ажил хийгдээгүй байгааг дүгнэн хэлэлцсэн.

Төрийн аудитын байгууллагаас сөрөг болон хязгаарлалттай дүгнэлт гарч албан шаардлага хүргэгдсэн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасны дагуу хариуцлага тооцох албан шаардлагыг биелүүлэх, төсвийн сахилга, хариуцлагыг бэхжүүлэх чиглэлээр зохих арга хэмжээг авч хариуц

2023 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулна уу.

Жич Төрийн аудитын байгууллагаас 2022 онд санхүүгийн тайланд сөрөг болон хязгаарлалттай дүгнэлт авсан дүгнэлт авсан зарим байгууллагын жагсаалтыг хавсаргав. Хавсралт 1 хуудас. Хүндэтгэсэн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Пүрэвдорж гээд ийм албан бичиг явуулна. Тэгээд энэ албан бичгийн хавсралтад байгаа нийтдээ 23 төрийн болон төрийн өмчийн компаниуд байгаа. Үүний нийт дүн нь бол 3 их наяд 46 тэрбум 406 сая төгрөгийн зөрчилтэй гарсан. Энэ байгууллагуудын албан тушаалтнуудад хариуцлага тооцох ийм албан бичиг явуулж байгаа юм. Тэгээд энэ дээр танилцуулъя. Тэгээд энэний дагуу бас тодорхой арга хэмжээ араас нь зайлшгүй авах ийм шаардлага гарч ирж байгаа.

Би Занданбат дарга таны хэлэх гэж байгааг мэдэж байгаа. Заримыг нь бол та бүхэн хууль хяналтын байгууллагад өгчихсөн байгаа. Дээрээс нь дахиад төсвийн ерөнхийлөн захирагч нарт нь хариуцлага тооцуулах саналаа хүргүүлчихсэн байгаа. Тийм учраас та бүхний ажлыг дэмжих замаар энэ ажлыг хийж байгаа гэдгийг бас даширамд хэлье. Ингээд танилцуулаа. Зарим гэдэгт, тийм зарим гэдэгт нь би бол энэ нэг яах вэ аудитын байгууллага бол 20 сая, 10 сая төгрөгийн зөрчил гаргасан маш их олон байгууллагуудыг бүгдийг нь гаргаад энэ тайлангаар бид надад өгчихсөн байгаа. Энэ тайлангаар маш их олон аж ахуйн нэгжүүд байгаа. ААН-үүд болон төрийн өмчийн, төрийн байгууллагууд байгаа. Тэгэхээр энэ эндээс бол мэдээж бүх хариуцлага тооцуулахаар бүх газар луу төрийн аудитын байгууллага бүгдээрээ бүгдэд нь албан бичиг явуулчихсан. Хариуцлага тооцуулахад.

Тэгэхээр эндээс голлон хэт өндөр зөрчилтэй тэр ААН-үүдийг л түүж, өөрөөр хэлбэл 100-аас дээш сая төгрөгийн

зөрчилтэй ААН-үүдийг л энд оруулсан байгаа гэдгийг хэлье. Тэгэхээр энэ жишээ нь Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Эрүүл мэндийн төв 10 сая төгрөгийн асуудалтай гэхэд түүн дээр хөөцөлдөөд Их Хурал яваад байх шаардлага байхгүй л гэж үзэж байгаа юм. Тэрийг бол тэртээ тэргүй төрийн аудитын байгууллага бүх албан хүсэлт шаардлагаа бүгдийг нь хүргүүлчихсэн. Тэрний дагуу бол зайлшгүй төсвийн ерөнхийлөгчийн захирагч нар арга хэмжээ авах ёстой. Тэгээд энэ дээр нь бас тодорхой хэмжээгээр бид, энэ бид нар энэ Монгол Улсын төсвийн тухай хуулийг баталдаг. Тэгээд энэ баталсан хуулийн маань хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэж байгаа учраас бид нар тодорхой зарим хэт өндөр зөрчил гаргасан тэр төрийн байгууллагууд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн удирдлагад хариуцлага тооцуулахаар бичиг явуулж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа. Би тэрийг тантай бас зөвшилцөж байгаад зарим аж ахуйн нэгжийг нь тэр хуулийн дагуу яах ёстойг нь би танай тантай зөвшилцье.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж танилцуулна. Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

10.04 цаг

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд, оролцож байгаа хүмүүст баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА